

ШУДАРГА БАЙДЛЫН БОДЛОГО, ҮҮРЭГ АМЛАЛТ

Стандарт, хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газар нь зах зээлд нийлүүлэгдэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц, тогтолцоо нь стандартын шаардлагад нийцсэн эсэхийг холбогдох хууль, журам, олон улсын стандарт, тохирлын үнэлгээний зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн хөндлөнгөөс тогтоо замаар хэрэглэгчийг зөв сонголт хийх, хуурамч бүтээгдэхүүнээс хамгаалах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд баталгаажуулалтаар дэмжлэг үзүүлнэ.

Стандарт, хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газар нь арилжаа, санхүүгийн болон бусад аливаа ашиг сонирхлын нөлөөнд автаяхгүйгээр тохирлын талаарх бодит нотолгоонд үндэслэж баталгаажуулалтын болон шийдвэр гаргах үйл ажиллагааг хараат бус, шударга байдлаар гүйцэтгэж ажиллана.

Бид аливаа хууль бус явдалтай эвлэршгүй байж, нээлттэй, нэг талыг баримтлахгүй, гадаад болон дотоод бүхий л сонирхогч талуудыг үл ялгаварлан, харилцан тэгш, тэнцвэртэй байдлыг хангаж баталгаажуулалтын байгууллагын нэр төрийг ухамсартайгаар хамгаалах болно.

Баталгаажуулалтын байгууллага болон түүний үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй аливаа үйл ажиллагаанд татагдан орохгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН
БҮТЭЭГДЭХҮҮН, ТОГТОЛЦООНЫ
БАТАЛГААЖУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

В.ГАНЗОРИГ

УКА0014
9096035 1117134581